



СОЁМБО МЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№44 /258/ 2022.03.04

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

Цаг үе, үйл явдал

ХЗЦ-ийн командлагч хошууч генерал Б.АМГАЛАНБААТАР ӨМНӨГОВЬ АЙМАГТ АЖИЛЛАВ



Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч, хошууч генерал Б.Амгаланбаатар гуравдугаар сарын 01-02-ны өдрүүдэд Зэвсэгт хүчний 167 дугаар ангид ажиллаа.

Цаашид тэрээр хөдөө орон нутагт байрлах харьяа бүх нэгтгэл, ангиуддаа ажиллах бөгөөд энэ нь 2021-2022 оны сургуулийн жилийн зорилго, зорилтын хэрэгжилт, цэргийн байр, бусад объектуудын нөхцөл байдалтай танилцаж, бие бүрэлдэхүүнд штабын бэлтгэлжилт, бэлэн байдал, цэргийн сургалт бэлтгэл, нийгмийн хамгаалал, алба хаагчдын ёс зүй, сахилга хариуцлага, хөдөлмөр хамгаалал зэрэг олон сэдвээр үүрэг чиглэл өгөхийн зэрэгцээ орон нутгийн удирдлагуудтай хамтын ажиллагаагаа тодотгох юм.

Хуурай замын цэргийн командлагчийн хамт ХЗЦК-ын

ажлын хэсгийнхэн ажиллаж, нэгтгэл, ангиудын ар тал, ахуй хангалт, удирдлагын баримт бичиг боловсруулалт, нууц хадгалалт, хамгаалалт, цэргийн сургалт бэлтгэлийн явц зэрэгтэй энэ үеэр танилцсан юм.

Хошууч генерал Б.Амгаланбаатараар ахлуулсан ажлын хэсэг зэвсэгт хүчний 167 дугаар ангид ажиллахдаа олон чухал асуудлыг хөндөж ярилцсаны дотор зэвсэглэл техникийг хадгалалтаас үе шаттайгаар гаргах, бие бүрэлдэхүүний нийгмийн хамгааллыг сайжруулах зорилгоор 60 айлын орон сууц барих тухай ангийн удирдлагуудтай ярилцсан юм. Мөн сургуулийн жилийн сургалтын төлөвлөгөөний дагуу явагдаж байгаа тус ангийн хээрийн гаралт, полигоны дадлагатай танилцжээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-7	-25

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
40	24

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,876.00	2,885.0
EUR	3,200.0	3,230.0
CNY	455.00	456.50
RUB	33.00	36.00
JPY	25.00	25.15
KRW	2.40	2.41

ЗУРХАЙ



2022.03.04 БААСАН ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 2/

ХАВРЫН ДУНД ХАРАГЧИН ТУУЛАЙ САРЫН ГУРВАН ХӨХ МЭНГЭТЭЙ УЛААН ЛУУ ӨДӨР

Үс засуулбал:

Хэл, ам, хэрүүл тэмцэл ирнэ

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

07.28-18.40

Барилдлага:

Идэр

Шүтэн барилдлага:

Нэр өнгө

Суудал: Үс

“ГАДААД ХЭЛИЙГ ТӨГС СУРАХУЙ” ЛЕКЦ

ҮБХИС-ийн Гадаад хэлний сургалтын төвийг түшиглэн жил бүр батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний анги байгууллагын цэргийн алба хаагчдад зориулан англи, орос, герман, франц, солонгос, хятад, турк хэлний анхан, бэлтгэл дунд, дунд 3 шатны дамжааг хичээллүүлж байна.

Гадаад хэлний сургалтын төвөөс дамжаанд суралцаж буй цэргийн алба хаагчдад зориулан спорт, соёлын арга хэмжээг тухайн суралцагчийн судалж буй хэлний хичээлтэй уялдуулан зохион

байгуулж байна. Тус төвөөс 2022 оны 3 дугаар сарын 1-ний өдөр “Гэгээ” сургуулийг үүсгэн байгуулагч, билигт гүүш доктор, профессор Доржсүрэнгийн Болдбаатарыг урьж “Гадаад хэлийг төгс сурахуй” сэдэвт лекцийг тавиулж, лекцийн төгсгөлд дамжааны суралцагчдын сонирхсон асуултын хүрээнд сонирхолтой ярилцлага өрнүүлсэн нь дамжааны суралцагсад гадаад хэл сурахад тулгарч буй бэрхшээлээс гарах, суралцах арга барилаа олоход нь чухал ач холбогдолтой арга хэмжээ боллоо.



ЭМЭГТЭЙ АЛБА ХААГЧИД ШИНЭЛЭГ БАЙДЛААР БАЯРАА УГТАНА



Зэвсэгт хүчний 340 дүгээр анги

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг угтан Зэвсэгт хүчний 340 дүгээр ангийн нийт эмэгтэй алба хаагчид баярын өдрөөрөө бэлэг дурсгалын зүйл авах бус хүмүүнлэгийн болоод нийгэмд чиглэсэн ажлуудыг 2022 оны 3 дугаар сарын 02-06 хооронд зохион байгуулан явуулах бөгөөд нээлтийн арга хэмжээг нөхөрсөг “Гар бөмбөг”-ийн тэмцээнээр эхлүүлж байна. “Гар бөмбөг”-ийн тэмцээнийг цэргийн гал тогооны бүрэлдэхүүн бие даан

зохион байгуулав. Түүнчлэн цаашид олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрлөгийн хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулах юм. Тодруулбал, бүтээлч ажил, урлаг, спорт, хүндэтгэлийн арга хэмжээ гэсэн хэсгүүдээс бүрдэх юм.

Бүтээлч ажлын хүрээнд хугацаат цэргийн алба хаагчдад 2 ээлжийн 168 ширхэг маскийг дотоод нөөц бололцоогоо ашиглан оёж өгөх, ангийн гадна орчны цэвэрлэгээний материал болох 10 ширхэг шүүрийг тус тус хүлээлгэн өгөхөөс гадна эрэгтэй офицер, ахлагч, ажилтан

алба хаагчдын үсийг ангийн үсчнээр үнэгүй засуулах зэрэг олон үр дүнтэй ажлуудыг тус өдрүүдэд зохион байгуулахаар төлөвлөвөө.

Мөн баярын өдрүүдэд алба хаагчдынхаа гэр бүлийг тэр дундаа азай буурлууддаа хүндэтгэл үзүүлэх үүднээс хамгийн өндөр настай гурван ээжийг шалгаруулж тусгайлан бэлдсэн гарын бэлгийг гардуулах юм.

Хүндэтгэлийн арга хэмжээг 2022 оны 3 дугаар сарын 6-ны өдөр зохион байгуулах бөгөөд урлагийн хэсэгчилсэн тоглолтыг үлээвэр найрал хөгжмийн бүрэлдэхүүн зохион байгуулж явуулснаар энэхүү онцлог баярын арга хэмжээ өндөрлөх юм.

ТӨГСӨЛТИЙН ШАЛГАЛТЫГ ЗОХИН БАЙГУУЛАВ

Ангийн 2021-2022 оны

сургуулийн жилийн сургалтын төлөвлөгөөний дагуу офицер, ахлагч нарын нэгдүгээр үеийн төгсөлтийн шалгалтыг энэ сарын 3-ны өдрийн 09.00 цагаас 12.30 цагийн хооронд Хилийн 0165 дугаар ангийн буудлагын талбайд сахилга зохион байгуулалтын өндөр түвшинд, осол зөрчилгүй амжилттай зохион байгуулж явууллаа.

Буудлага хийх бүрэлдэхүүнд буудлагын үед дагаж мөрдөх аюулгүйн арга хэмжээний дүрэм, зааврыг уншиж танилцуулан, хүн нэг бүрээр гарын үсэг зуруулан ажилласан. Буудлагын үед ПМ гар буу болон автоматын нэгдүгээр дасгалыг хийж гүйцэтгэсэн.

Ахлах дэслэгч Б.ДОЛГОРСҮРЭН



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН

2,271,724 /69.8%/

ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН

2,173,135 /66.8%/

ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН

1,025,368 31,5%
105,671 /3,2%/

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН
8328 +112

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ
96

ЭДГЭРСЭН
8113

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 442,331,939

Эдгэрсэн

Нийт: 374,931,028

Нас барсан

Нийт: 6,001,494

ЭРЧҮҮДИЙН ИЛҮҮДЭЛ ЖИН БА ТАРГАЛЛАТ

Насанд хүрсэн хүн илүүдэл жин ба таргалалттай гэдгийг биеийн жингийн индекс (БЖИ)-ээр тодорхойлдог. Насанд хүрсэн хүний БЖИ ≥ 25 км/м² байвал илүүдэл жин, БЖИ ≥ 30 км/м² бол таргалалттай гэж үзэнэ.

ИЛҮҮДЭЛ ЖИН БОЛОН ТАРГАЛЛАТЫН ШАЛГАМ

- Эрүүл бус буюу тургэн зоол, хүнсний харгалзаа хэмээн гэдэг.
- Гар орон болон ажилын байрнд суугаа хэв маяг давамгайл, хөдөлгөөний хэмжээг орсон.

ТАРГАЛЛААС ҮСЭХ ХҮНДЭРЛЭГ:

- Цусны даралт ихэснэ
- Хөндөр
- Чихрийн шижин ихэснэ
- Элэгний өвчлөлт
- Тархины эвдрэл
- Тусламж
- Тусламж
- Тусламж

МОНГОЛ УЛСАД

15-49 насны 2 эрэгтэй түүхний 1 нь илүүдэл жинтэй эсвэл таргалалттай

Таргалалт 14,6% Илүүдэл жин 34,2%

Эрчүүдийн дунд илүүдэл жин ба таргалалтын таргалалт ихэвчлэн буурч байна.

15-19 нас - 17,7% 20-29 нас - 33,2%
30-39 нас - 59,2% 40-49 нас - 63,9%

Цахим шууданд

“АХЛАГЧИЙН АЛБАНЫ ХӨГЖИЛ БА ХЭТИЙН ТӨЛӨВ”



Зэвсэгт хүчний 013 дугаар анги
 Ангийн 2021-2022 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу ангийн удирдлага, алба салбарын

захирагч нарын болон ахлагч дунд эрдэм шинжилгээний онолын бага хурлыг зохион байгуулсаар байна. Энэ удаа тус ангийн ахлагч нарын дунд “Ахлагчийн албаны хөгжил ба хэтийн төлөв” сэдэвт

эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг илтгэх хурлыг зохион байгууллаа.

Хуралд батальон, салбаруудын ахлагч нараас шалгарсан 17 илтгэлийг хэлэлцүүлсэн бөгөөд тэдгээрээс ахлах ахлагч Ц.Эрдэнэбаатар, Н.Пүрэвсүрэн, ахлагч Л.Бямба-Очир нарын илтгэл шагналт байрт шалгарснаар дараагийн шатны шалгаруулалтад өрсөлдөх эрхээ аваад байна.

Энэхүү эрдэм шинжилгээ, судалгааны хурал нь санал, дүгнэлт, шүүмжлэлээр дүүрэн нөхөрсөг уур амьсгалд өрнөж, дэвшүүлсэн зорилго, зорилтуудаа бүрэн хангасан юм.

Тэргүүн ахлагч Ч.ТҮВШИН

АНГИЙН “МАРШ ТАКТИК ТУСГАЙ БЭЛТГЭЛИЙН АВАРГА” ТОДРОВ



Зэвсэгт хүчний 325 дугаар анги
 Ангийн 2021-2022 оны сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу “Марш тактик тусгай бэлтгэлийн аварга” тасаг шалгаруулах тэмцээнийг 2022 оны 2 дугаар сарын 28-аас 3 дугаар сарын 1-ний өдрүүдэд гарааны өмнөх болон 10км-ийн марш гэсэн хоёр үе шаттайгаар амжилттай зохион байгууллаа.

Марш тактик тусгай бэлтгэлийн аварга тасаг шалгаруулах тэмцээнд эрэгтэй 8 тасаг, эмэгтэй 3 тасаг оролцон авхаалж самбаа, хурд хүчээ сорин өрсөлдлөө. Эрэгтэй тасгуудын I байрт ахлах ахлагч Э.Ганзориг ахлагчтай “38-тай аавууд” тасаг 55:28 секундээр, II байрт ахмад Н.Мөнхбаатар ахлагчтай “Офицерууд” тасаг 56:55 секундээр, III байрт ахлагч М.Жамъяандорж



ахлагчтай “Хүлгүүд” тасаг 1:02:35 секундээр тус тус шалгарав.

Эмэгтэй тасгуудын I байрт дэд ахлагч Э.Мөнгөнсор ахлагчтай “Elegant” тасаг 55:41 секундээр, II байрт ахлагч Б.Түгдмаа ахлагчтай “Harris” тасаг 56:33 секундээр тус тус шалгарч өргөмжлөл, алт, мөнгө, хүрэл медалийн эзэн болж, мөнгөн шагналаар шагнагдлаа.

АХЛАХ АНГИЙН СУРАГЧИД ЦЭРГИЙНХНИЙ НЭГ ӨДӨРТЭЙ ТАНИЛЦЛАА



Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл
 “Монгол цэргийн өдөр”, орчин цагийн Зэвсэгт хүчний 100, 101 жилийн ойг тохиолдуулан хүүхэд багачуудад цэрэг-эх оронч үзэл хүмүүжил төлөвшүүлэх, эх орныхоо тусгаар тогтнолын үнэ цэнийг ойлгуулах, цэрэг дайчдын үйл ажиллагааг танилцуулах зорилгоор Төв аймгийн Зуунмод сумын ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдын нэг өдрийг зохион байгууллаа.

хүчний 016 дугаар нэгтгэлийн үйл ажиллагаатай танилцан, дайчин алдрын танхим, сургалтын дадлагын хотхоноор зочилж, хугацаат албаны дайчидтай яриа өрнүүлсэн юм.

Мөн бэлтгэл хурандаа Б.Нямхүү сурагчдад “Эх оронч үзэл, хүмүүжил” сэдвээр сонирхолтой лекц тавьж, үргэлжлүүлэн цэргийн алба хаагч болон сурагчдын хамтарсан урлагийн тоглолтыг нэгтгэлийн бүрэлдэхүүнд толилуулсан юм. Сурагчдын сэтгэлд тод дурсамж үлдээсэн өөр нэг арга хэмжээ нь хугацаат цэргийн алба хаагчидтай хамт 3000 метрийн

гүйлтийн уралдаан байв. Уралдаанд хугацаат цэргийн алба хаагчид манлайлж, сурагчид тэднээр бахархаж буйгаа уламжилж байлаа.

Ү р г э л ж л ү ү л э н цэрэг, эх орны сэдэвт шүлгийн уралдааныг зохион байгуулахад “Хүмүүн” цогцолбор ахлах сургуулийн 11а ангийн сурагч С.Мягмарсүрэн тэргүүлж, V дунд сургуулийн 116 ангийн сурагч Б.Цолмон, “Хүмүүн” цогцолбор ахлах сургуулийн 10б ангийн сурагч Б.Цэнгүүнбаяр нар удаах байруудад шалгарав.

Энэ үеэр сурагчдын сэтгэгдлийг сонсоход “Эх оронч үзэл, итгэл үнэмшилтэй, эх орон, тусгаар тогтнол, түүх, эх хэл, өв соёлоороо бахархах төлөвшилтэй байх нь манай улсын маш том дархлаа юм. Дарга, цэрэггүй, хөгшин залуугүй л энэ дархлаагаа мэддэг байх ёстой. Өнөөдрийн арга хэмжээ нь цэргийн ах, эгч нарынхаа ажил үйлсээр бахархах, тэднийг хүндэтгэн хайрлах сэтгэгдлийг бидэнд үлдээлээ. Ялангуяа монгол хүн болж төрснөөрөө бахархах, улс орныхоо тусгаар тогтнолыг дээдлэх үзлийг төлөвшүүлж чадлаа” гэсэн юм.

ХОНОГИЙН ХЭЭРИЙН СУРГУУЛИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Зэвсэгт хүчний 284 дүгээр анги
 Ангийн 2021-2022 оны сургуулийн жилийн цэргийн сургалт, бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу 2022 оны 02 дугаар сарын 28-аас 3 дугаар сарын 1-ний өдрүүдэд хонгийн хээрийн сургуулийг зохион байгууллаа.

Сургалт даллага ангийн байнгын байрлалаас хөдөлгөөн эхэлж Амгалан дулааны станц ХХК, Шижир амралтын уулзвар зам, өндөрлөг 1326.0, Туул гол амралтын газар, Найман шарга амралтын газрын район гэсэн маршрутаар

60 километрийн явган марш, хонгийн хээрийн сургуулийг явуулсан юм. Энэ хүрээнд ҮОХЗХ, Тактик тусгай бэлтгэл, Амьд гарах ухаан, Сэтгэл зүйн бэлтгэл гэсэн хичээлүүдийг дадлагаар орсон бөгөөд эдгээр нь офицер, ахлагч нарын бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлжилтийн түвшинг дээшлүүлэхийн сацуу цэргийн хэргийн мэдлэгийн ур чадварыг нэмэгдүүлсэн сургалт дадлага болж өнгөрлөө. Үргэлжлүүлээд эдгээр өдрүүдэд тус ангийн байлдааны буудлагатай тактик хээрийн сургууль хужир буланд дах сургалтын төвд явагдаж байна.

Ахлах дэслэгч М.ОЧГЭРЭЛ



“САРАН ХӨХӨӨ” ТЕАТРЫН УРАН БҮТЭЭЛЧИД ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 336 ДУГААР АНГИД



Зэвсэгт хүчний 336 дугаар анги
 Монгол цэргийн өдөр”, орчин цагийн Зэвсэгт хүчний 100, 101 жилийн ойг тохиолдуулан Дорноговь аймгийн соёл урлагийн байгууллага, олон нийт, иргэдтэй хамтарч хүүхэд, залууст цэрэг-эх оронч үзэл төлөвшүүлэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх зорилгоор хэд хэдэн арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлж байна.

Үүний нэг нь энэ сарын 02-ны өдөр тус аймгийн “Саран хөхөө” театрын уран бүтээлчдийг урьж, цэргийн гэрээт болон хугацаат албаны дайчдадаа уянгын драмын жүжиг болон “Бид эх орны хөвгүүд” урлагийн тоглолтыг толилууллаа. Тоглолтоор эх орноо хамгаалж байгаа баатарлаг цэрэг эрийн тухай өгүүлж, цэрэг-эх орны дуугаар ая дуу өргөсөн нь дайчдад ихэд таалагдсан юм.

СУРГАЛТ, ДАДЛАГА АМЖИЛТТАЙ БОЛЖ ӨНДӨРЛӨВ

Байлдааны гавьяаны улаан тугийн одонт, жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит Зэвсэгт хүчний 336 дугаар анги 2021-2022 оны сургуулийн жилийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу хээрийн гаралт, полигоны дадлага, ротын байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургуулийг ангийн Сургалтын төвийн районд амжилттай зохион байгууллаа. Хээрийн гаралт, полигоны дадлагын явц, зохион байгуулалтад Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалын Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн дарга, хурандаа Д.Өлзийбаяр даргатай комиссын бүрэлдэхүүн шалган туслах ажлыг явуулж, тодорхой үүрэг чиглэл өгч, хичээл сургалт, дадлага өмнөө тавьсан зорилгоо бүрэн биелүүлээ гэж дүгнэлээ.

Ахлах дэслэгч А.АЛТАНХУЯГ

